



МОНГОЛ УЛС
ХОВД АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2019 оны 10 сарын 01 өдөр

Дугаар 1/629

Ховд

Т Эрүүл мэндийн чиглэлээр мэргэжлийн үйл
ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрлийн
комиссыг шинэчлэн байгуулах тухай

Аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн тухай Монгол Улсын хуулийн 16 дугаар зүйлийн 16.2.2, Эрүүл мэндийн тухай хуулийн 19 дүгээр зүйлийн 19.2, 19.3 дахь заалтуудыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Аймгийн хэмжээнд эрүүл мэндийн чиглэлээр мэргэжлийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл олгох комиссын бүрэлдэхүүнийг нэгдүгээр, Эрүүл мэндийн тусгай зөвшөөрлийн комиссын ажиллах удирдамжийг хоёрдугаар хавсралтаар тус тус баталсугай.

2. Эрүүл мэндийн чиглэлээр мэргэжлийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрлийн үйл ажиллагаанд нь хяналт үнэлгээ хийж, цаашдын хэрэгцээ шаардлагад нийцүүлэн тусгай зөвшөөрөл олгох, мэргэжил арга зүйгээр хангах зэрэг зохион байгуулалтын арга хэмжээг тасралтгүй авч хэрэгжүүлэхийг Эрүүл мэндийн чиглэлээр мэргэжлийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл олгох комисс /Ц.Мягмарсүрэн/-т үүрэг болгосугай.

3. Энэхүү захирамж гарсантай холбогдуулан аймгийн Засаг даргын 2015 оны А/556 дугаар захирамжийг хүчингүй болсонд тооцсугай.

ЗАСАГ ДАРГА

Б.ДҮГЭРЖАВ



Аймгийн Засаг даргын 2019 оны 10 дугаар
сарын 01.-ний өдрийн А/629 дүгээр
захирамжийн нэгдүгээр хавсралт



**АЙМГИЙН ХЭМЖЭЭНД ЭРҮҮЛ МЭНДИЙН ЧИГЛЭЛЭЭР
МЭРГЭЖЛИЙН ҮЙЛ АЖИЛЛАГАА ЭРХЛЭХ ТУСГАЙ
ЗӨВШӨӨРӨЛ ОЛГОХ КОМИССЫН БҮРЭЛДХҮҮН**

- Комиссын дарга: -Аймгийн Эрүүл мэндийн газрын дарга
- Гишүүд: -Аймгийн Эрүүл мэндийн газрын Эмнэлгийн тусlamжийн хэлтсийн дарга
-Аймгийн Эрүүл мэндийн газрын Хяналт шинжилгээ үнэлгээ мэдээллийн хэлтсийн дарга
-Аймгийн Засаг даргын Тамгын газрын Нийгмийн Бодлогын хэлтсийн Эрүүл мэндийн асуудал хариуцсан мэргэжилтэн
-Аймгийн Нийгмийн даатгалын хэлтсийн Эрүүл мэндийн даатгалын тасгийн дарга
-Мэргэжлийн хяналтын газрын Эрүүл мэнд, боловсрол, хүнсний хяналтын хэлтсийн дарга, улсын ахлах байцаагч
-Хэрэглэгчийн эрх ашгийг хамгаалах нийгэмлэгийн төлөөлөл /тэргүүн/
Нарийн бичгийн дарга: -Аймгийн Эрүүл мэндийн газрын Эрүүл мэндийн чиглэлээр мэргэжлийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрлийн асуудал хариуцсан мэргэжилтэн

-оOo-

Аймгийн Засаг даргын 2019 оны 10 дугаар
сарын 01-ний өдрийн А/629 дүгээр
захирамжийн хоёрдугаар хавсралт

УДИРДАМЖ

Эрүүл мэндийн тусгай зөвшөөрлийн комиссын
ажиллах тухай

Нэг. Нийтлэг үндэслэл

1.1. Аймгийн “Эрүүл мэндийн чиглэлээр мэргэжлийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрлийн комисс” нь Аж, ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.12, Эрүүл мэндийн тухай хуулийн 13 дугаар зүйл, 15 дугаар зүйл, 40, 41 дүгээр зүйл, Эм, эмнэлэгийн хэрэгслийн тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.1, 9 дүгээр зүйлийн 9.1 дэх хэсэгт тус тус заасан үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл олгох, сунгах, зөвшөөрлийг түдгэлзүүлэх, хүчингүй болгох, зөвшөөрөлд нэмэлт өөрчлөлт оруулах, тусгай зөвшөөрлийн комиссын дэргэд шинжээчээр ажиллах мэргэжлийн байгууллага, мэргэжилтнийг томилох үйл ажиллагааг удирдан зохион байгуулахад энэхүү удирдамжийг мөрдлөг болгоно.

1.2. “Эрүүл мэндийн чиглэлээр мэргэжлийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрлийн комисс” (цаашид “комисс” гэх) нь үйл ажиллагаандaa Аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн тухай хуулийн 9 дүгээр зүйлд заасан зарчмаас гадна дор дурдсан зарчмыг баримтлан ажиллана. Үүнд:

- Хүн амын эрүүл мэндийн бодит хэрэгцээг үндэслэх,
- Тусlamж, үйлчилгээ үзүүлэгчдээс зохиомлоор үүсгэх эрүүл мэндийн хэрэгцээ, санхүүгийн эрсдлээс иргэдийг хамгаалах,
- Үйлчлүүлэгчдийн аюулгүй байдлыг хангах,
- Тусlamж үйлчилгээний чанар, хүртээмжийг сайжруулах,
- Хувь хүний эдийн засгийн эрхийг хамгаалах,
- Төрийн үйлчилгээний ил тод, шуурхай, нээлттэй байдлыг хангах,
- Ашиг сонирхлын зөрчилгүй байх,

1.3. Мэргэжлийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрлийн комисс нь 7 хүний бүрэлдэхүүнтэй, орон тооны бус байх бөгөөд дарга, нарийн бичгийн дарга, гишүүдээс бүрдэнэ.

1.4. Эрүүл мэндийн чиглэлээр мэргэжлийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрлийн комиссын нарийн бичгийн дарга нь Эрүүл мэндийн газрын мэргэжлийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрлийн асуудал хариуцсан мэргэжилтэн байна.

1.5. Аймгийн Эрүүл мэндийн чиглэлээр мэргэжлийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрлийн комисс нь Эрүүл мэндийн байгууллагад мэргэжлийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөлтэй холбоотой өдөр тутмын үйл ажиллагааг хариуцан гүйцэтгэх ажлын албатай байна.

1.6. Ажлын албыг Эрүүл мэндийн газрын даргын тушаалаар баталж, ажлын албаны ажиллах чиг үүргийг хуульд нийцүүлэн боловсруулж мөрдүүлсэн байна.

1.7. Мэргэжлийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрлийн комисс нь үндсэн чиг үүргээ хэрэгжүүлэхдээ шаардлагатай тохиолдолд шинжээчдийг татан оролцуулж болно.

Хоёр.Комиссын ажлын чиг үүрэг, үйл ажиллагаа

2.1. Комисс нь дараах чиг үүрэг, үйл ажиллагааг хэрэгжүүлнэ. Үүнд

2.1.1. Эрүүл мэндийн чиглэлээр мэргэжлийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөлтэй холбоотой асуудлаар ажлын албаны үйл ажиллагаанд хяналт тавих, үүрэг чиглэл өгөх;

2.1.2. Эрүүл мэндийн байгууллагын мэргэжлийн үйл ажиллагааг эрхлэх тусгай зөвшөөрлийн бодлого, зохицуулалт, эрх зүйн орчинг боловсронгуй болгох талаар санал боловсруулж, эрүүл мэндийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад уламжлах;

2.1.3. Эрүүл мэндийн чиглэлээр мэргэжлийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл олгоход эрүүл мэндийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын баталсан баримтлах чиглэлийг баримтлах;

2.1.4. Холбогдох байгууллагын тодорхойлолт, тусгай зөвшөөрөл хариуцсан мэргэжилтэн, шинжээчдийн дүгнэлт, акт зэргийг үндэслэн эрүүл мэндийн байгууллагын тусгай зөвшөөрлийг олгох, сунгах, түдгэлзүүлэх, хүчингүй болгох асуудлыг хэлэлцэн, шийдвэр гаргах;

2.1.5. Тусгай зөвшөөрлийн комисс нь аймгийн хэмжээнд алслагдсан байршлын хүн амд тусlamж үйлчилгээг ойртуулах, хүртээмжийг нэмэгдүүлэхэд чиглэсэн тусlamж үйлчилгээг илүүтэй дэмжих;

2.1.6. Эрүүл мэндийн чиглэлээр мэргэжлийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл олгоход үйл ажиллагааны давхардал бүхий ажил үйлчилгээ, ашиг сонирхлын зөрчил бүхий зөвшөөрлийг олгоход хязгаарлалт хийх;

2.1.7. Комиссын ажиллах хэлбэр нь хурал байх ба гишүүдийн олонхийн саналаар Эрүүл мэндийн байгууллагын мэргэжлийн үйл ажиллагааг эрхлэх тусгай зөвшөөрлийн асуудлыг шийдвэрлэх;

2.1.8. Хурлаар хэлэлцэх асуудлын төлөвлөгөөг комиссын дарга батлах ба шаардлагатай үед комиссын даргын шийдвэрээр төлөвлөгөөнд тусгагдаагүй асуудлыг нэмэлтээр хэлэлцэж болно;

2.1.9. Нарийн бичгийн дарга нь комиссын даргын баталсан хурлын төлөвлөгөө, хурлаар хэлэлцэх асуудлын танилцуулгыг гишүүдэд хурал болохоос 3-аас доошгүй хоногийн өмнө цахим болон цаасан хэлбэрээр хүргүүлж, хурлын тэмдэглэлийг хөтөлнө.

2.1.10. Комиссын дарга хурлын дэгийг баталж, хурлыг ажлын 21 хоногт 1 удаа хийх ба шаардлагатай тохиолдолд ээлжит бус хурал зарлан хуралдуулах бөгөөд комиссын гишүүдийн 70-аас доошгүй хувь оролцсон тохиолдолд хурал хүчин төгөлдөр байна;

2.1.11. Комиссын гишүүд хурлаар хэлэлцэх асуудалтай бүрэн танилцаж, саналаа бэлтгэж ирэх ба оролцох боломжгүй тохиолдолд саналаа бичгээр болон цахимаар ирүүлж болно;

2.1.12. Комисс нь шаардлагатай гэж үзвэл комиссын хурлаар хэлэлцэх асуудлын хүрээнд холбогдох мэргэжилтэн, шинжээч, тусгай зөвшөөрөл хүсэгч аж ахуйн нэгж байгууллага, иргэнийг оролцуулна;

2.1.13. Комисс нь хэлэлцсэн асуудлаар санал боловсруулж, тэмдэглэл хөтөлж, хурлын тэмдэглэл, шийдвэр болон тусгай зөвшөөрлийн гэрчилгээнд комиссын дарга гарын үсэг зурж баталгаажуулна;

2.1.14. Тусгай зөвшөөрөл олгосон эрүүл мэндийн байгууллагын үйл ажиллагаанд холбогдох мэргэжлийн байгууллагаар хяналт хийлгэж, хэрэглэгчдийн зүгээс гаргасан гомдол, маргааныг шийдвэрлэнэ.